



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ ТӨҮГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/53/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Аудитор: П.Амарсанаа
Утас: 260512 Цахим хаяг: Amarsanaap@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн Бизкон аудит ХХК-ийн
Захирал Л.Отгонбаяр
Утас: 312773 Цахим хаяг: info@bizcon.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
5.1 Шилэн дансны мэдээлэл	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
8. Аудитын илрүүлэлт	15
8.3 Албан шаардлага	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НА	Нотлох ажилт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨА	Төрийн өмчийн аудит
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ ТӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ О.ТҮВШИНДЭМБЭРЭЛ
ТАНАА

2022. 03.15 № 09 / 558
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудитаар залруулагдаагүй 68.9 сая төгрөгийн зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа букуу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 заалтууд, Нийцсэн бөгөөд зохистой байх, Тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулсан ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Тайлант онд нийт орлогыг 375.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 375.0 сая төгрөг байхаар баталсан байна. Гүйцэтгэлээр нийт 380.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 433.0 сая төгрөгийн зардал гарган, 52.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

\\10.10.10.20\Bichig_Kheregl\Yawsan_Bichig\2022\0315 Audit\1in 2 Gazar - 38.Docx

001050841

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

ТӨБЗГ-аас баталсан 2021 оны зорилтот түвшинд Монгол кино нэгтгэл ТӨҮГ нь 32 бүлэг уран бүтээл бүтээхээр төлөвлөснөөс улсын төсвийн санхүүжилтээр 12 бүлэг кино уран бүтээл туурвисан байна. Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний гүйцэтгэлийг 80 хувь гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



\\10.10.10.20\Bichig_KhereglYawsan_Bichig\2022\0315 Auditin 2 Gazar - 38.Docx

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	46,563,462.51	86,570,548.70
1.1.2	Дансны авлага	33,034,780.39	23,896,907.86
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	734.36	914,217.15
1.1.6	Бараа материал	517,346,573.64	517,491,573.64
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	596,945,550.90	628,873,247.35
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,059,158,020.53	2,963,076,647.88
1.2.2	Биет бус хөрөнгө	770,178,372.81	769,678,372.84
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,829,336,393.34	3,732,755,020.72
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,426,281,944.24	4,361,628,268.07
2.1.1.1	Дансны өглөг	10,382,520.00	-
2.1.1.3	Татварын өр	1,277,133.24	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	500,000.00	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	12,159,653.24	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	12,15,653.24	-
2.3	Өмч	145,352,055.93	145,352,055.93
2.3.1	төрийн	145,352,055.93	145,352,055.93
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,878,331,806.60	3,878,331,806.60
2.3.9	Хуримтлагдсан ашиг	390,438,428.47	337,944,405.28
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,414,122,291.00	4,361,628,267.81
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,426,281,944.24	4,361,628,268.07

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	178,085,548.93	164,641,818.19
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	15,068,160.76	10,065,575.85
3	Нийт ашиг (алдагдал)	163,017,388.17	154,576,242.34
4	Түрээсийн орлого	160,857,954.48	215,891,464.81
5	Хүүний орлого	1,411,064.77	-
8	Бусад орлого	1,277,363.62	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	506,153,591.74	422,061,652.66
12	Бусад зардал	1,322,936.63	900,000.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(57,142,464.71)	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(238,040,530.13)	(52,494,023.19)
19	Орлогын татварын зардал	141,106.48	-
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(238,040,530.13)	(52,494,023.19)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(238,040,530.13)	(52,494,023.19)
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	(238,040,530.13)	(52,494,023.19)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	124,660,692.93	3,878,331,806.60	683,545,637.43	4,686,583,136.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга			(4.84)	(4.84)
Залруулсан үлдэгдэл	124,660,692.93	3,878,331,806.60	683,545,632.59	4,686,538,132.12
Өмчид гарсан өөрчлөлт	20,691,363		(95,418,032.22)	(74,726,669.22)
Тайлант үеийн үр дүн			(181,039,171.90)	(181,039,171.90)
Зарласан ноогдол ашиг			(16,650,000.00)	(16,650,000.00)
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	145,352,055.93	3,878,331,806.60	390,438,428.47	4,414,122,291.00
Залруулсан үлдэгдэл	145,352,055.93	3,878,331,806.60	390,438,428.47	4,414,122,291.00
Тайлант үеийн үр дүн			(52,494,023.19)	(52,494,023.19)
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	145,352,055.93	3,878,331,806.60	337,944,405.28	4,361,628,267.81

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн	369,191,283.18	424,082,229.32
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	363,007,122.18	378,116,411.14
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	21,601,818.18
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,276,861.00	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	3,907,300.00	24,364,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	492,137,181.97	382,525,065.45
1.2.1	Ажиллагчдад төлсөн	132,398,537.53	172,085,566.63
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	38,459,659.00	43,523,678.50
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	93,721,131.50	28,899,182.10
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	109,220,984.26	66,965,673.51
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	13,174,377.00	12,267,500.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	141,106.48	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	51,360,230.20	57,579,164.71
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	117,612.00	267,300.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	53,543,544.00	937,000.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(122,945,898.79)	41,557,163.87
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн	2,411,064.77	50,000.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	1,000,000.00	50,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	1,411,064.77	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	3,745,500.00	3,180,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	681,500.00	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,650,000.00	-
2.2.5	Бусад олгосон зээл болон урьдчилгаа	1,414,000.00	3,180,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,334,435.23)	(3,130,000.00)
3	Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн	300,000.00	1,580,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	300,000.00	1,580,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	16,650,000.00	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	16,650,000.00	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(16,350,000.00)	1,580,000.00
4	Валютын ханшийн зөрүү	12,691.91	(77.68)
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(140,617,642.11)	40,007,086.19
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	187,181,104.62	46,563,462.51
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	46,563,462.51	86,570,548.70

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр /Баримтат кино/	бүлэг	32	32	12	(20)	37.5
1	Улсын төсвөөр хийж гүйцэтгэсэн ажил	мян.төг	45,100.0	45,000.0	36,000.0	(9,000.0)	80.0
	Гэрээгээр гүйцэтгэсэн ажил /Баримтат кино/	мян.төг	15,000.0	50,000.0	-	(50,000.0)	-
	Үйлчилгээний орлого	мян.төг	117,985.4	100,000.0	128,641.8	28,641.8	128.6
	Түрээсийн орлого	мян.төг	160,858.0	150,000.0	215,891.5	65,891.5	143.9
	Үйл ажиллагааны бусад орлого	мян.төг	2,690.5	30,000.0	-	(30,000.0)	-
2	Нийт орлого	мян.төг	341,633.9	375,000.0	380,533.3	5,533.3	101.5
3	Нийт зардал	мян.төг	522,544.7	375,000.0	433,027.2	58,027.2	115.5
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	104,508.9	84,000.0	40,647.1	(43,352.9)	48.4
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	(238,040.5)	-	(52,494.0)	(52,494.0)	-
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	(238,040.5)	-	(52,494.0)	(52,494.0)	-
6	Төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	173,174.9	141,340.4	108,037.2	(33,303.2)	76.4
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	16,650.0	-	-	-	-
8	Нийт ажиллагсдын тоо	мян.төг	19	15	16	0	106.7
9	Нийт цалингийн сан	мян.төг	165,059.4	124,876.8	173,936.0	49,059.2	139.3
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	мян.төг	723.9	693.8	905.9	212.1	130.6
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	1.5	1.0	1.1	0.1	113.8
12	Хөрөнгө оруулалт	мян.төг	71,808.7	-	-	-	-
13	Нийт авлага	мян.төг	33,035.5	40,000.0	24,811.1	(15,188.9)	62.0
	Үүнээс: Найдваргүй	мян.төг	-	-	18,000.0	18,000.0	-
14	Нийт өглөг	мян.төг	12,159.7	2,000.0	-	(2,000.0)	-
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	12,159.7	2,000.0	-	(2,000.0)	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бөхөн аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад Мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг и баримтаар баталгаажуулж ажиллах, олон жилийн насжилттай авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах зэрэгтэй холбогдуулан өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 15-наас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Бизкон аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Наранбат, аудитор О.Хишигмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ц.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 22/06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Соёлын яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас тайлант хугацаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 522.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 5.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын зорилго нь уран сайхны болон баримтат кино бүтээж түүгээр дамжуулан монгол орны түүх, өв уламжлал, ёс заншил, үндэсний бахархлыг хойч үедээ амьд дуу, дүрсээр өвлүүлэхэд оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг кино хальс боловсруулах, баримтат болон уран сайхны кино бүтээх, иргэд аж ахуйн нэгжүүдэд киноны мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, түүнд нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа явуулдаг, Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ТӨААТҮГ статустай байна. Өмчийн 100 хувийг төр, үүнээс Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 100 хувийг эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Монгол кино нэгтгэл ТӨҮГ нь Сайд нарын зөвлөлийн 32 дугаар тогтоолоор улсын кино зургийн хорооны харьяа кино үйлдвэрийн газар болж үүсгэн байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол кино нэгтгэл ТӨҮГ нь ТУЗ-ийн бүрэлдэхүүнгүйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд жил бүр эд хөрөнгийн үзлэг тооллогын ажлын үр дүнг захирлын хурлаар хэлэлцэж хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих талаар арга хэмжээ авсан байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөхгүйгээр орон тоог тогтоосон хэмжээнд ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол кино урлагийг дэмжих тухай хууль 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөх;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;

- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журам;
- Хөдөлмөрийн тухай хууль 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөх;

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	46,563.5	86,570.5	40,007.0
Авлага	33,034.8	23,896.9	(9,137.9)
Татвар, НДШ-ийн авлага	0.7	914.2	(913.5)
Бараа материал	517,346.6	517,491.6	0.1
Үндсэн хөрөнгө	3,059,158.0	2,963,076.6	(96,081.4)
Биет бус хөрөнгө	770,178.4	769,678.4	(0.5)
Нийт хөрөнгийн дүн	4,426,281.9	4,361,628.3	(64,653.6)
Богино хугацаат өглөг	12,159.6	-	(12,159.6)
Эздийн өмч	145,352.1	145,352.1	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,878,331.8	3,878,331.8	-
Хуримтлагдсан ашиг	390,438.4	337,944.4	(52,494.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,426,281.9	4,361,628.3	(64,653.6)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 86.6 сая төгрөг болж 40.0 сая төгрөгөөр өссөн нь борлуулалтын орлого өссөнөөс шалтгаалжээ.

Авлагын үлдэгдэлд НӨАТ-ын 0.9 сая төгрөгийн авлага байна. Авлагын үлдэгдэлд 18.0 сая төгрөгийн 7 жилийн өмнө үүссэн тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд 517.5 сая төгрөгийн бараа материал байгаа ба ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,963.0 сая төгрөг болж 96.1 сая төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Өр төлбөр данс 12.1 сая төгрөгөөр буурсан нь дансны өглөг 10.3 сая, татварын өглөг 1.3 сая, бусад богино хугацаат өр төлбөр 0.5 сая төгрөгийг тайлант хугацаанд төлж барагдуулснаас шалтгаалсан байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 337.9 сая төгрөг болж 52.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 38.9 сая төгрөгөөр буюу 11.4 хувиар өссөн нь түрээсийн орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 146.7 сая төгрөгөөр буюу 25.3 хувиар буурсан нь Засгийн газрын 43 дугаар тогтоолыг биелүүлэх зорилгоор хэмнэлтийн горимд ажилласнаас шалтгаалсан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Монгол кино нэгтгэл ТӨҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 645 дугаар тушаалаар Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 375.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 375.0 сая төгрөгөөр, ашиг алдагдалгүй байхаар төлөвлөсөн. Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зардал төлөвлөөгүй байна.

Гүйцэтгэлээр 380.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 433.0 сая төгрөгийн зардал гарган, 52.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт 2. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин /мянган төгрөг/

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
0	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт	мян.төг					
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	мян.төг	117,985.4	100,000.0	128,641.8	28,641.8	128.6
2	Бусад орлого	мян.төг	2,690.5	30,000.0	-	(30,000.0)	-
3	Түрээсийн орлого	мян.төг	160,858.0	150,000.0	215,891.5	65,891.5	143.9
4	Нийт орлого	мян.төг	341,633.9	375,000.0	380,533.3	5,533.3	101.5
5	Нийт зардал	мян.төг	522,544.7	375,000.0	433,027.2	58,027.2	115.5
6	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	104,508.9	84,000.0	40,647.1	(43,352.9)	48.4
7	Татварын өмнөх ашиг	мян.төг	(238,181.6)	-	(52,494.02)	(52,494.02)	-
8	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	(238,181.6)	-	(52,494.02)	(52,494.02)	-

Нийт орлогын гүйцэтгэл 380.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 5.5 сая төгрөг буюу 1.5 хувиар давсан нь үйлчилгээний орлого, түрээсийн орлогын өсөлт голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 433.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 58.0 сая төгрөг буюу 15.5 хувиар илүү зарцуулсан байна. Энэ нь цалингийн зардлын өсөлттэй холбоотой байна.

Тайлант онд 52.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь цалингийн зардлыг төлөвлөснөөс илүү зарцуулсан нь нөлөөлжээ.

Өмнөх онд алдагдалтай ажилласан тул тайлант онд ТӨБЗГ-т ногдол ашиг төвлөрүүлээгүй. 2021 онд байгууллагын дүрмэнд өөрчлөлт оруулж "Үл хөдлөх хөрөнгийн түрээс"-ийн үйл ажиллагааг үндсэн үйл ажиллагаа болгон өөрчилж ТӨБЗГ-аар дүрмээ шинэчлэн батлуулсан. Ингэснээр түрээсийн үйл ажиллагаа нь байгууллагын үндсэн орлого болсон тул түрээсийн орлогоос ТӨБЗГ-т орлого төвлөрүүлэхгүй болсон байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд 170 мэдээлэл байршуулахаас, 164 мэдээллийг хугацаандаа оруулж 6 мэдээлэл хугацаа хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд шилэн дансны хуульд заасан мэдээлэл хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

6. ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Завсрын аудитаар 39.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 2.4 сая төгрөгийг залруулж, 34.8 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, 1.9 сая төгрөгийн зөвлөмж хэрэгжээгүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд нэмж тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 албан шаардлага, 1 зөвлөмж өгснөөс зөвлөмж бүрэн биелсэн, 2 албан шаардлагын биелэлт 78 хувьтай, нийт 89 хувийн биелэлттэй байна. Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд 2-15 жилийн хугацаатай 28.2 сая төгрөгийн он удаан жил болсон авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж өгсөн боловч, 18.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	81,848.9	1	63,848.9	1	18,000.0	78.0
Зөвлөмж	1	24,535.8	1	24,535.8	-	-	100.
Нийт дүн	3	106,384.7	2	88,384.7	1	18,000.0	89.0

Худалдан авалт хийхдээ ажил гүйлгээг и баримтаар баталгаажуулж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй, зөрчлийг тайлант онд давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлсэн.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үндсэн болон нэмэгдэл цалин хөлсний бүртгэл, тооцооллыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 68.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 68.9 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 68.9 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 5.2 сая төгрөгөөс их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

8.3 Албан шаардлага

1. Тайлант онд худалдан авалт хийх болон ажил үйлчилгээ гүйцэтгүүлэхэд гарсан 1.9 сая төгрөгийн зардлыг төлбөрийн дахин давтагдашгүй и баримтаар баталгаажуулаагүй нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14. "төлбөрийн баримт" гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн нь: Мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг и баримтаар баталгаажуулаагүй алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтийг шалгахад тайлант хугацаанд үндсэн болон нэмэгдэл цалингийн зардал төлөвлөснөөс 49.1 сая төгрөгөөр буюу 39.3 хувиар хэтрүүлэн зарцуулсан зөрчилд Монгол улсын Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.3. төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх;

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ-ын санхүүгийн тайланд Эн Эм Си Жи ХХК-иас авах авлага болох 7 жилийн өмнө үүссэн 18.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасны зөрчсөн;

Шийдвэрлэсэн нь: Авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Монгол кино нэгтгэл ТӨҮГ	АХГ-2022/53/НА-СТА-ТӨА	Анхан шатны баримт бүрдүүлэлт е-баримтгүй, хувь хүний тамга, дардастай байна.	Мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг и баримтаар баталгаажуулж ажиллах	1	1,916.8					1	1,916.8				
2	Монгол кино нэгтгэл ТӨҮГ	АХГ-2022/53/НА-СТА-ТӨА	Авлага болох 7 жилийн өмнө үүссэн 18,000.0 үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй байна.	Олон жилийн насжилттай авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах	1	18,000.0					1	18,000.0				
3	Монгол кино нэгтгэл ТӨҮГ	АХГ-2022/53/НА-СТА-ТӨА	2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтэд цалингийн зардал 49,059.0 мянган төгрөгөөр буюу 39.3 хувиар төлөвлөгөөнөөс хэтрүүлэн зарцуулсан байна.	Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор төсвийн хэмнэлтийн талаар тусгасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах	1	49,059.0					1	49,059.0				
ДҮН					3	68,975.8					3	68,975.8				
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	Монгол кино нэгтгэл ТӨҮГ	АХГ-2022/53/НА-СТА-ТӨА	Шилэн дансанд 6 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	1	-					1	-				
ДҮН					1						1					
НИЙТ ДҮН					4	68,975.8					4	68,975.8				



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 388/АО150458

Улаанбаатар хот

АНГ-2022/153/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эн Эм Си Жи ХХК-аас авах олон жилийн насжилттай 18,000,000.0 төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна. Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулан, дээрх зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын Захирал О.Түвшиндэмбэрэл, Ерөнхий нягтлан бодогч Г.Төрбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БИЗКОН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.ОТГОНБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khoreg\Alban_Shaardlaga\2022\0315_Auditin_2_Gazar-60.Docx

00108C1101



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 387/АД150458

Улаанбаатар хот

АХГ-2022/153/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтийг шалгахад тайлант хугацаанд үндсэн болон нэмэгдэл цалингийн зардлыг төлөвлөснөөс 49,059,000.00 төгрөгөөр буюу 39.3 хувиар хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 “үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох”, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3. “төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж, зөрчлийг арилган, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын захирал О.Түвшиндэмбэрэл, ерөнхий нягтлан бодогч Г.Төрбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БИЗКОН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.ОТГОНБАЯР



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

© 10.10.10.20:Bichig_Khereg/Alban_Shaardlaga/2022/0315_Auditin_2_Gazar-61.Docx

00108C1103



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 389/АО150458

Улаанбаатар хот

АХГ-2022/53/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 170 мэдээлэл байршуулахаас, 164 мэдээллийг хугацаандаа оруулж 6 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг ил тод, хугацаанд нь байршуулж байх, зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын Захирал О.Түвшиндэмбэрэл, Ерөнхий нягтлан бодогч Г.Төрбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БИЗКОН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.ОТГОНБАЯР



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban_Shaardlaga\2022\0315_Auditin_2_Gazar-62.Docx

0010801105



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 390/А0150458
АХГ-2022/53/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн худалдан авалт хийхдээ ажил гүйлгээг и баримтаар баталгаажуулж байх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд зөрчлийг давтан гаргаж цахим и баримтаар баталгаажуулаагүй 1,916,800.00 төгрөгийн ажил гүйлгээ гаргасан байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14 "төлбөрийн баримт" гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдлийг хангаж, худалдан авалт бүрийг төлбөрийн и баримтаар баталгаажуулан ажиллаж, зөрчлийг арилган биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын захирал О.Түвшиндэмбэрэл, ерөнхий нягтлан бодогч Г.Төрбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БИЗКОН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
П.ОТГОНБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.20\Bichig_Kherig\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-59.Docx

0010801099

